

ДИЗАЙН, ЗУРАГ ЗҮЙН ОЛИМПИАДЫН МЕДИА ДИЗАЙНЫ ТӨРЛИЙН III ШАТНЫ ДААЛГАВАР

Даалгавар: “МОНГОЛ СОЁЛ” СЭДЭВТ БОГИНО ХЭМЖЭЭНИЙ ХАЙЧИЛБАР
АНИМЕШН БҮТЭЭХ

Зорилго: Монгол үндэстний өв соёлыг судлан ирээдүй хойчид таниулах, шинэ зуунд
хэрхэн уламжлах боломжийг эрэлхийлэх

Хугацаа: 2026-04-04

Хэлбэр: Видео анимейшн

Баг: II шатнаас шалгарсан багууд оролцоно. Үнэлгээнд багийн гишүүдийн тоо биш
ажлын гүйцэтгэлийн чанар гол үзүүлэлт болно!

Гүйцэтгэх хугацаа: /120 мин/

БЭЛТГЭХ ЗҮЙЛС:

- Зохиолыг кино зохиолын хэлбэрт оруулан бичих
- Бүх дүрүүдийг зурж төлөвлөх
- Дүрүүдийг хайчилбараар хийж бэлдэх
- Орчны деталиудыг хийж бэлдэх /Сцени буюу тайз бэлдэх/
- Даалгаварын гүйцэтгэлийн тайлан бичвэрийг А4 хэмжээтэй цахим хэлбэрээр (.docx, .pdf) бэлдэнэ. Үүнд:
 - Багийн нэр, сургууль, анги
 - Багийн гишүүдийн овог, нэр, цахим шуудангийн хаяг, утасны дугаар
 - Зохиол
 - Сториборд
 - Дүрүүдийн судлагаа, тайлбар
 - Даалгавар гүйцэтгэхэд ашигласан ном, материал, эх сурвалжийн жагсаалт
 - Хяналтын бичлэг хийсэн бол видео файлыг хурдасгасан хэмжээ /Даалгаварыг гүйцэтгэсний дараа нэмж бичнэ/
- Анимешны зурагт хуудас /постер/ - А2 хэмжээтэй, .PNG форматаар хадгалсан, өнгөтөөр хэвлэх боломжтой, үзэсгэлэнд тохиромжтой бэлтгэсэн байх
- Даалгавар гүйцэтгэх үйл явцыг онлайнаар дамжуулах ZOOM, GOOGLE meeting аппликейшн ажиллах видео камер бүхий төхөөрөмж /гар утас, таблет, зөөврийн буюу вэб камер бүхий суурин компьютер г.м/
- Хяналтын бичлэг хийх төхөөрөмжид CapCut зэрэг бичлэгийн хурдыг нэмэгдүүлэх видео аппликейшн суулгасан байна
- Стоп моушен бүтээх програм суулгасан, дижитал зураг авах боломжтой ухаалаг төхөөрөмж /гар утас, таблет г.м/

- Зүсэх, хайчлах хэрэгсэл: Хайч, цаасны хутга, зүсэх дэвсгэр гэх мэт
- Зурах, будах, тэмдэглэх хэрэгсэл: Цаас, харандаа, бийр, будаг гэх мэт
- Бэхлэх, тогтоох хэрэгсэл: Хавчаар, тулгуур, наалт гэх мэт.
- Дэвсгэр: Тайзыг байрлуулах тохирох форматтай хавтан, самбар гэх мэт
- Бичлэг хийх төхөөрөмжийг бэхлэх суурь
- Бичлэг хийх орчныг гэрэлтүүлэх нэмэлт гэрэл

ОЛИМПИАДЫН БОДИТ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР

2026-04-04-ИЙ 10:00 ЦАГТ ЭХЭЛНЭ.

Эхлэх цаг: 10:00. Дуусах цаг: 12:00 /120 минут/

Мэйл илгээх сүүлийн хугацаа: 2026 оны 4-р сарын 4-ний 14 цаг 00 минут

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Багш сурагчид онлайн олимпиад эхлэхээс 30 минутын өмнө бүх бэлтгэлээ хангаж байраа эзэлж, онлайн дамжуулалтын болон хяналтын бичлэг хийх төхөөрөмжүүдийг байрлуулсан байна.
- Шууд дамжуулалтыг эхэлснээс хойш камерын хяналтаас орж гарахгүй тул хувийн бэлтгэлээ базаах /Ариун цэврийн өрөө орох, уух цэвэр ус г.м/
- Дүрүүдийг бүтээхдээ хөдөлгөөнтэй холболт бүхий үе мөчтэй хийж гүйцэтгэнэ.
- Зурагт хуудасны нягтаршил /resolution/ 300dpi-с дээш чанартай байна.
- Хяналтын видеод багийн гишүүдийн ажиллагаа, бүтээлийн явцыг тодорхой харуулсан байна. Бичлэг хийх төхөөрөмжийн камерын өнцгийг үйл явцыг бүрэн харагдаж байхаар тохируулж байрлуулах буюу удирдагч багш эсвэл туслах хүн бичлэг хийж болно.
- Хяналтын камер ажиллуулах төхөөрөмжид
- **Бичлэгийн эхлэл, төгсгөлд эхэлсэн, дууссан цагийг харуулна.**
- Хяналтын видеог үйл явцыг гүйцэтгэх хугацаанд эхэлснээс дуусах хүртэл /120 минут/ тасалдалгүй онлайн аар харуулна. Төхөөрөмжийн цэнэгийг анхаарна уу!
- Дамжуулалтыг олимпиадын зохион байгуулах комисс бичиж авах бөгөөд сүлжээ, дамжуулалтын эрсдлээс сэргийлэн багууд өөрсдөө хяналтын видеог чанартай бичиж, хурдасгасан байдлаар .mp4 форматаар видео файл болгон илгээж болно. Видео бичлэгийн хурдасгасан хэмжээг гүйцэтгэлийн тайлан бичвэрт зааж өгнө.
- Бүтээлийн файл, бичвэр, видео бичлэгийг цахим шуудангийн ch.munkhbayar@msue.edu.mn хаягаар илгээнэ.